



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/27

Амардалай

Үйлдвэрлэлийн осол, хурц, хордлого судлан
бүртгэх комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 29.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн 3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүд: Ц.Билэг-Ариун (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Т.Мөнхтуяа (ЭМТ-ийн эрхлэгч)

Б.Цэвэгсүрэн (ЭМТ-ийн сувилагч)

Б.Энхдэлгэр (ХЭХАХМэргэжилтэн)

Ш.Должин (ЕБС-ийн эмч)

Л.Мөнхжаргал / ХХЭ /

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм, холбогдох бусад дүрэм журмын хүрээнд ажил олгогчид үйлдвэрлэлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгөх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан нөхцлийг тогтоох, судлан бүртгэж дүгнэлт гарган ажиллахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/29 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

101401051